



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 03 өдөр

Дугаар А/539

Есөнбулаг

Түрээслүүлэгчийг сонгон шалгаруулах
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 51 дүгээр тогтоол, аймгийн Онцгой комиссын 2023 оны 01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дэлгэр сумын төвлөрсөн дулааны үйл ажиллагааг түр хариуцан ажиллуулах аж ахуй нэгж, хуулийн этгээдийг сонгон шалгаруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Л.Хаш-Эрдэнэ (аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга)

Гишүүн: Х.Лхагважав (аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн)

Д.Отгонжаргал (аймгийн Засаг даргын Тамгын газрын эрчим хүчний хяналтын улсын байцаагч)

Б.Бямбадорж (Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга)

Ц.Амарсанаа (Онцгой байдлын газрын гамшгаас хамгаалах төлөвлөлт, бэлэн байдал хариуцсан ахлах мэргэжилтэн, гамшгаас хамгаалах хяналтын улсын байцаагч, хошууч)

Ж.Билэгсайхан (Орон нутгийн өмчийн газрын ахлах мэргэжилтэн)

Б.Лхагва-Очир (Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн орон тооны гишүүн)

Т.Сүхбаатар (Дэлгэр сумын Засаг даргын тамгын газрын дарга)

Г.Туул (Дэлгэр сумын сургуулийн захирал)

Г.Цэрэнжав (Дэлгэр сумын цэцэрлэгийн эрхлэгч)

Нарийн бичгийн дарга: Б.Золзаяа (Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн)

2. Захирамжийн хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Л.Хаш-Эрдэнэ)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

О.АМГАЛАНБААТАР

